

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗРААС 2019 ОНЫ
 ДӨРӨВДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
 /2019.03.26 - 2019.04.25/

2019 оны 04 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5	6
1.		Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх.	Тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд албан хаагчдаас авч, нэгтгэн Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөнд тусгах саналыг байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд авч, нэгтгэн Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.04.25-26-ны өдрүүдэд хүргүүлсэн.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Захиргааны ахлах мэргэжилтэн
2.	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тоон мэдээг 2018 онтой харьцуулан гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Гадаадын иргэн, харьяатын газраас гаргадаг инфографик мэдээнд тусгах тус газрын 2019 оны 4 дүгээр сарын статистик тоог 2018 оны мөн үетэй харьцуулан гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.04.25-ны өдөр хүргүүлэв. Мэдээгээр 2019.03.26–2019.04.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 17 үүнээс хариутай албан бичиг 6, явсан бичиг 9, ирсэн өргөдөл 1, гомдол 0 байгаа бол 2018.12.11-2019.04.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 78 үүнээс харицтай албан бичиг 39 явсан бичиг 52, ирсэн өргөдөл 1, гомдол 0 байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн

1	2	3	4	5	6
				Харин 2017.12.11 - 2018.04.25-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн бичиг 53 үүнээс хариутай албан бичиг 26, явсан бичиг 46, ирсэн өргөдөл 0, гомдол 0 байна.	
3.		Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Албан даалгаврын биелэлтийг үнэн зөв гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Байгууллагын даргын батлан гаргасан 2017 оны 01, 03, 04, 05, 06, 07, 2018 оны 02, 04, 06, 08, 09, 10, 2019 оны 02, 03 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.05.01-ний өдөр хүргүүлсэн.	Нийт албан хаагчид
4.	Виз, бүртгэлийн чиглэлээр	Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх.	Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна.	Нийт 63 орны 299 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 9 байна. Үүнд, нэг удаагийн орох 243, хоёр удаагийн орох 2, олон удаагийн орох 23, нэг удаагийн гарах-орох 15, хоёр удаагийн гарах-орох 5, олон удаагийн гарах-орох 2, дамжин өнгөрөх 0, түр ирэгчийн бүртгэл 32, хасалт 34, оршин суух зөвшөөрлийн хасалт 11 байна. Үүнээс гадна тус газрын албан хаагчийн алдаатай бичсэн визийн хуудас 2 ширхэгийг хүчингүй болгож, Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон визийг шинээр 4 орны 12 гадаадын иргэнд олгосон. Оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон виз 3 орны 5 гадаадын иргэн байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч нар

1	2	3	4	5	6
5.		Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах.	Гадаадын иргэний мэдээллийг “ISM” систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна.	Монгол Улсад орох визгүй нийт 3 орны 3 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан байна. Харин гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр нийт 6 орны 9 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно. Шүүх, прокурор, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч нар
6.	Хяналт шалгалтын чиглэлээр	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага болон гадаадын иргэн ажиллаж буй нийтийн хоол, үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийх	Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг тус газрын даргад танилцуулсан байна.	Төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус 2, нийт 3 хяналт шалгалтан хийж 9 аж ахуйн нэгж, 125 гадаадын иргэн хамрагдлаа. Хяналт шалгалтын дүнг тухай бүр тус газрын даргад танилцуулав. Тухайлбал, Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2019.03.26-ны өдөр баталсан 10/04 дугаартай удирдамжийн даруу төлөвлөгөөт бус шалгалтыг мөн сарын 27-ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт дэвсгэрт хийв. Шалгалтаар Ган бөмбөлгийн үйлдвэрт хөдөлмөр эрхэлж байсан 1 орны 13 гадаадын иргэн биедээ бичиг баримтгүй явсан зөрчил илэрсэн тул Зөрчлийн тухай хуулийн 16.2.1.3-т зааснаар хүн тус бүрээр 1300000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар

1	2	3	4	5	6
				<p>Мөн Сэргэлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 1 аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй 1 орны 41 гадаадын иргэнийг шалгахад зөрчил илрээгүй. Түүнчлэн Баянчандмань сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 1 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж угсрахаар орж ирсэн 1 орны 12 гадаадын иргэнийг шалгахад зөрчил илрээгүй болно. Тус удирдамжтай шалгалтанд нийт 3 аж ахуйн нэгж, 1 орны 66 гадаадын иргэн хамрагдлаа.</p> <p>Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2019.04.04-ний өдөр баталсан 10/05 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтыг мөн өдөр Төв аймгийн Баянцогт, Баянчандмань суманд хийв. Шалгалтанд 1 орны 7 гадаадын иргэн хамрагдсан ба зөрчилгүй үйл ажиллагаа явуулж байв.</p> <p>Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2019.04.15-ны өдөр баталсан 10/06 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт шалгалтыг энэ сарын 23-ны өдөр Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг, Сэргэлэн сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хоолны газар, төмрийн үйлдвэр, цементийн үйлдвэр зэрэг газруудад хийсэн.</p>	

1	2	3	4	5	6
				Шалгалтанд 2 орны 52 гадаадын иргэн хамрагдсан бөгөөд бичиг баримтын зөрчилгүй байлаа.	
7.		Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах.	Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 27 гадаадын иргэнд 3,120,000 төгрөг, 5 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 5/ 590,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.	Хяналтын улсын ахлах байцаагч, Хяналтын улсын байцаагч нар
8.		Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна.	Тус газраас албадан гаргасан гадаадын иргэн 0 ба төвөөс 6 орны 13 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож тодорхойлолт үйлдэв.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар
9.		Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.	Хил дээр тавих хяналт сайжирсан байна.	Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 12 орны 70 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно. Иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 6 орны 31 гадаадын иргэнийг угтан авч буй Монгол Улсын 5 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.	Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нар

1	2	3	4	5	6
10.		Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулах.	Төрийн үйлчилгээний албан хаагчдын хийсэн ажлыг нэгтгэн гаргаж ур чадварын нэмэгдэл олгуулах саналыг газрын даргад танилцуулж тушаал гаргасан байна.	Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу төрийн үйлчилгээний 5 албан хаагчдаас 4 албан хаагчид тус газрын даргын 2019.04.24-ний өдрийн Б/05 дугаар тушаалаар ур чадварын нэмэгдэл олгосон болно. Байгууллагын даргын 2019 оны Б/19 дүгээр тушаалын дагуу 1 албан хаагч сануулах сахилгын шийтгэлтэй тул ур чадварын нэгэмдэл олгоогүй.	
11.	Хүний нөөц, сургалтын чиглэлээр	Төрийн албаны зөвлөлийн цахим санд албан хаагчдын мэдээллийг шивж оруулан баяжилт хийх.	Тус газрын албан хаагчдын 2019 оны 3 дугаар сарын нэмэгдлийг оруулсан байна.	Төрийн албаны зөвлөлийн цахим санд тус газрын албан хаагчдын мэдээлэл болох 2019 оны 3 дугаар сард авсан нэмэгдлийг /зэрэг дэв, төрийн алба хаасан хугацаа, ур чадвар, унаа, хоол/ шивж оруулан баяжилт хийлээ. Мөн байгууллагын даргын 2019 оны Б/103 дугаар тушаалын дагуу төрийн албанаас чөлөөлөгдсөн 1 албан хаагчийн мэдээллийг тус цахим сангаас хаслаа.	Захиргааны ахлах мэргэжилтэн
12.		Захиргааны албан хаагчдад зориулсан сургалтад холбогдох албан хаагчийг хамруулах ажлыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байна.	Байгууллагын даргын 2019 оны Б/95 дугаар “Захиргааны албан хаагчдын сургалт зохион байгуулах тухай” тушаалын дагуу тус газрын захиргааны ахлах мэргэжилтэн 3 хоногийн сургалтад хамрагдав. Сургалтаар архив, албан хэрэг хөтлөлт, аюулгүй байдал, дотоод хяналт шалгалтын үндсэн ойлголт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал зэрэг чиглэлээр хичээл орж, орон нутагт тулгарч буй хүндрэлийн талаар хэлэлцэв.	

1	2	3	4	5	6
13.		<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдүгээр шатны төлөвлөгөөний иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг суртачилах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах</p>	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаарх ойлголтыг бататгасан байна.</p>	<p>Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран 2019.04.24-ний өдөр сургалт зохион байгуулж эрүүгийн тасгийн эдийн засгийн эрүүгийн мөрдөгч, ахлах дэслэгч М.Батцэнгэл “Эдийн засгийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, анхаарах асуудал” сэдвийн хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хилийн боомтоор нэвтрүүлэхийг завдсан оролдлогууд, арга барил, илрүүлсэн тохиодолд авах арга хэмжээний талаар мэдээлэл хүргэж, тус газрын 15 албан хаагч хамрагдав.</p>	<p>Хяналтын улсын ахлах байцаагч, Захиргааны ахлах мэргэжилтэн</p>
14.	<p>Санхүү, хангалт, үйлчилгээний чиглэлээр</p>	<p>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах.</p>	<p>Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.</p>	<p>Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 196,506,900 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 118,595,780 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 12,953,524 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 7,103,465 төгрөг зарцуулсан.</p>	<p>Ахлах нягтлан бодогч</p>

1	2	3	4	5	6
15.		Тус газрын 2019 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлан гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Санхүүгийн тайланг үнэн зөв нэгтгэн гаргаж Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн байна.	Тус газрын 2019 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлан гаргаж 2019.04.12-ны өдөр Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.	Ахлах нягтлан бодогч
16.		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах.	НД-ын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна.	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2019.04.02-ны дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 147,225,200 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 123,125,870 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан. Нийгмийн даатгалын шитгэлийн тайланг гарган 2019.04.05-ны дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 23,005,681 төгрөгөөр тооцоо нийлэв.	Ахлах нягтлан бодогч, Нярав
17.		Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах.	Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна.	Албан хаагчдад шийтгэлийн хуудас 0, визийн хуудас 300 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.	
18.		Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах.	Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна.	Бараа материалын өссөн дүнгээр 5,926,170 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна.	

1	2	3	4	5	6
19.		Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу тухай бүр шийдвэрлэх.	Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана.	Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт өссөн дүнгээр 445,165 төгрөг, байрны түрээс 12,343,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс уруу шилжүүлсэн.	Ахлах нягтлан бодогч
20.		Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх.	Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байх.	Хүү торгууль өссөн дүнгээр 15,600,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 87,784,050 төгрөг, визийн хуудас 6,534,090 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн 2019.04.05-ны өдрийн дотор Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн.	
21.		Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.	Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 3,916,500 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан.	Ахлах нягтлан бодогч, Нярав
22.		Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх.	Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна.	Тус газрын нийт 27 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 2, сургалтын чөлөөтэй 1 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.	Нярав

1	2	3	4	5	6
23.		Нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх	ХУД-ийн НДХ, Татварын хэлтэст хүргүүлсэн байна.	Тус газар нийгмийн даатгал, татварын тайланг гаргаж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын хэлтэст хүргүүлсэн.	Ахлах нягтлан бодогч, Нярав
24.	Өргөдөл, гомдлын чиглэлээр	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна.	Агаарын замын боомт хариуцсан газарт ирсэн 1 /албан хаагч/ өргөдөл, 0 гомдлыг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, уг өргөдөлд “Бүртгэл-хяналтын карт” хөтөлж, газрын даргад танилцуулан шийдвэрлүүлэхээр Захиргаа, удирдлагын газарт 2019.04.16-ны өдөр хүргүүлсэн. Тус газарт энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол байхгүй бөгөөд мэдээг 2019.04.25-ны өдөр Захиргаа, удирдлагын газар болон Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.	Захиргааны ахлах мэргэжилтэн
25.	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр	Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.	Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсөн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн нийт 17 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, хариутай 6 албан бичигт “Бүртгэл-хяналтын карт” хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллав. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар “Бүртгэл-хяналтын карт”-д тэмдэглэв.	

1	2	3	4	5	6
				Түүнчлэн тус газраас 9 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.	
26.		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх.	Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна.	Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд газрын даргын баталсан 1 тушаал, тус газарт ирсэн 17, явсан 9 албан бичиг, энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлэв.	
27.		Тус газарт 2018 онд үүссэн баримтын бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах.	Холбогдох журмын дагуу тус газрын архивт шилжүүлсэн баримтын бүртгэл хөтөлсөн байна.	Тус газарт 2018 онд үүссэн архивын нэгжийг хүлээн авах хуваарийн дагуу архивт 198 хадгаламжийн нэгж хүлээн авч, бүртгэлжүүлэх ажлыг хийсэн бөгөөд байнга, түр, 70 жил хадгалах хугацаагаар ялгаж байршуулахаар ажиллаж байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн
28.		Архивын өрөөний чийг, дулааныг хэмжиж бүртгэл хөтлөх.	Хэмжилтийг өдөр бүр хийж, бүртгэл хөтөлсөн байна.	Тус газрын архивын өрөөний чийг, дулааныг 2019.03.26-2019.04.25-ны өдрүүдэд өдөр бүр хэмжиж дэвтэрх бичилт хийн ажиллав. Дулаан 20-25C, чийгшил 20-30RH байна.	
29.		Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний тус газартай холбоотой арга хэмжээний биелэлт гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв гаргаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Тус газарт ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй судалгааг үзүүлэлт тус бүрээр гаргаж, бүртгэлжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 65,397,380 төгрөгийн тоног төхөөрөмж байгаа бөгөөд албан хаагчдын өдөр тутмын ажлыг хийж гүйцэтгэхэд бүрэн ашиглагдаж байгаа талаар Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст 2019.03.27-ны өдөр хүргүүлсэн.	

1	2	3	4	5	6
30.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах.	Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна.	Дотоод сүлжээний 7, техник хэрэгслийн 5, нийт 12 дуудлага хүлээн авч засварлаж ажиллалаа. Иргэний нисэхийн ерөнхий газрын цахилгаан тасрахтай холбогдуулан 2019.04.16-ны өдөр “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын ирэгч, явагчийн танхимд байрлах ажлын өрөөний 2 компьютерт “ISM” програм ажиллагаагүй болсон нөхцөлд ашиглах виз хэвлэх програмыг /төвөөс хөгжүүлсэн/ шинээр дахин суулгасан. Төв аймаг дахь ахлах мэргэжилтэний өрөөний компьютерийг форматлан, дотоод сүлжээ болон хэрэглээний бүх програм хангамжийг суулгав. Тайлант хугацаанд нийт 3 удаа цахим хурлын төхөөрөмжийг холбон, Хилийн 0218-р ангиас сүлжээг залгуулан хурлыг дамжуулсан болно.	Сүлжээний инженер
31.	Олон нийттэй харилцах чиглэлээр	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна.	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ,	Ахлах нягтлан бодогч

1	2	3	4	5	6
				Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл. Түүнчлэн Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл.	
32.		Тус газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Тус газрын сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Байгууллагын цахим хуудсанд тус газраас 2019 оны гуравдугаар сард хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл, гомдлын мэдээ, зохион байгуулсан сургалт, дөрөвдүгээр сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллав.	Захиргааны ахлах мэргэжилтэн, Сүлжээний инженер
33.	Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр	Хилийн боомтын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах үг хэллэгийг агуулсан гадаад хэлний ярианы дэвтэрийн төслийг бэлтгэх.	Монгол-Хятад, Монгол-Герман, Монгол-Солонгос хэлний ярианы дэвтэрийг хэвлүүлэхэд бэлэн болгосон байна.	Байгууллагын чиг үүргийг “Чингис хаан” олон улсын нисэх буудалд хэрэгжүүлэхэд тус газрын албан хаагчид өдөр тутам гадаадын иргэдтэй харилцдаг тул хилийн боомтод өдөр тутам хэрэглэгддэг Монгол - Хятад, Монгол - Герман,	Хяналтын улсын байцаагч, Мэргэжилтэн

1	2	3	4	5	6
				Монгол-Солонгос 200 орчим үг, өгүүлбэр оруулсан “Хилийн боомтод ашиглагдах хэрэглээний гадаад хэлний гарын авлага”-ын эх бэлтгэж, хэвлүүлэхэд бэлэн болгосон.	Хяналтын улсын ахлах байцаагч

Төлөвлөсөн: 33
Биелсэн: 32
Хагас биелсэн: 1
Биелээгүй: 0
Хувь: 99

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗАР